



НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2018 оны 05 сарын 08 өдөр

Дугаар А/398

Улаанбаатар хот

Агаарын бохирдлыг бууруулах талаар  
авах зарим арга хэмжээний тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, Агаарын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.1, 8.1.6, Засгийн газрын 2018 оны 62 дугаар тогтоол, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2017 оны 01/19 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Дараахь арга хэмжээ авч хэрэгжүүлэхийг доор дурдсан байгууллага, албан тушаалтнуудад даалгасугай:

1.1. Нийслэл Улаанбаатар хотод 2019 оны 05 дугаар сарын 15-ны өдрөөс эхлэн түүхий нүүрс хэрэглэхийг хориглосонтой холбогдуулан сайжруулсан түлш үйлдвэрлэх, нөөцлөх газрын асуудлыг шийдвэрлэх талаар санал боловсруулж ажиллахыг Нийслэлийн Газрын алба /Э.Болорчулуун/-нд;

1.2. агаарын чанарыг сайжруулах бүс дэх сайжруулсан түлшний дэмжлэг авах зорилтот бүлгийн айл өрхүүдийн судалгаа гаргаж ажиллахыг Нийслэлийн Нийгмийн халамжийн газар /Т.Оюунчимэг/-т;

1.3. агаарын чанарыг сайжруулах бүсэд 2018-2019 онд сайжруулсан түлш тараах хороодын судалгааг гаргаж, төвийн 6 дүүргийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж байгаа иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын бага, дунд, том оврын халаалтын зуухны байгууламжийн дахин бүртгэл, тооллогыг зохион байгуулж ажиллахыг Нийслэлийн Агаарын бохирдлыг бууруулах газар /Б.Цацрал/-т.

2. Энэ захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж, дүнг цаашид авах арга хэмжээний шийдвэрийн төслийн хамт 2018 оны 05 дугаар сарын 15-ны өдрийн дотор Нийслэлийн Засаг даргын зөвлөлд танилцуулахыг Нийслэлийн Засаг даргын ногоон хөгжил, агаарын бохирдлын асуудал хариуцсан орлогч Ж.Батбаясгаланд даалгасугай.

НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГА  
БӨГӨӨД УЛААНБААТАР ХОТЫН  
ЗАХИРАГЧ



С.БАТБОЛД

111020001860